

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ ДАРГА НАРЫН

2023 ОНД ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТ /БҮТЭН ЖИЛ/

2023 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр.

Шийдвэрийн дугаар	Заалт Д/д	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжилт, үр дүн, үр нөлөө	Өөрийн үнэлгээ /тайлбар/	ХШҮ-ний үнэлгээ
ГСА-ЗД-23/01	3.1	Говьсүмбэр аймгийн Засаг дарга, Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны даргын 2023 онд хамтран ажиллах гэрээ 2023.04.03-ны № ГСА-ЗД-23/01	3.1Хуулиар олгогдсон чиг үүргийн хүрээнд “Говьсүмбэр аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, “Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, үйл ажиллагааны хөтөлбөрийн төлөвлөгөө, аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөө, харьяа яамдын сайдаас аймгийн Засаг даргатай байгуулсан хамтран ажиллах гэрээнд тусгагдсан орон нутагт авч хэрэгжүүлэх арга хэмжээг байгууллагын стратеги, гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжилтийг зохион байгуулж, үр дүнг тайлагнана.	Байгууллагын стратеги төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжилтийг ханган ажиллах	Байгууллагын 2021-2024 оны стратеги төлөвлөгөөг “Говьсүмбэр аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, “Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, үйл ажиллагааны хөтөлбөрийн төлөвлөгөөтэй уялдуулж боловсруулж аймгийн Засаг даргаар батлуулан үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байгаа. Тайлан мэдээг холбогдох хэлтэс хуулийн хугацаанд гаргаж өгсөн. Үр дүн: Байгууллагын бодлогын баримт бичгийн хэрэгжилт хангагдана.	100	
ГСА-ЗД-23/01	3.2		3.2 Иргэдийг соён гэгээрүүлэхэд чиглэсэн арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх	мэдээллийн цаг ажиллуулах	Тайлант хугацаанд давхардсан тоогоор 74 байгууллагын 249 албан хаагчдад зориулж мэдээллийн цаг гарган мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. Үр дүн:	100	

					Манай байгууллагаас зөвлөн туслах үйлчилгээ авах иргэдийн тоо өссөн.		
ГСА-ЗД-23/01	3.3		3.3 Төр, төрийн бус байгууллага, иргэн, аж ахуйн нэгжийн хамтын ажиллагааг сайжруулах, өргөжүүлэхэд чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх	Холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах санамж бичиг байгуулах	Авилгатай тэмцэх газар, Аймгийн Прокурорын газар, аймгийн Цагдаагийн хэлтэс болон төрийн Аудитын газартай хамтран ажиллаж байна. Үр дүн: Төрийн байгууллагын хамтын ажиллагаа сайжирна.	100	
ГСА-ЗД-23/01	3.4		3.4 Иргэдийг мэдээллээр хангах, мэдээ, мэдээллийг хурдан шуурхай хүргэх, аливаа уулзалт, зөвлөгөөн, хурал цуглаанд иргэдийн санал бодлыг сонсож, шийдвэрлэж ажиллах	Цахим хуудасны мэдээллийг тухай бүр тогтмол шинэчлэх	Иргэдийг мэдээллээр хангах, мэдээ мэдээллийг түргэн шуурхай хүргэх үүднээс байгууллагын www.sanhuaudit.gs.gov.mn цахим хаягт мэдээллийг тогтмол байршуулж шинэчилж байна. Тайлант хугацаанд цахим хуудсыг шинэчилсэн бөгөөд нийт 160 удаагийн мэдээллийг оруулсан. Үр дүн: Мэдээ мэдээллийг түргэн шуурхай иргэдэд хүргэж байна.	100	
ГСА-ЗД-23/01	3.5		3.5 Иргэдэд үйлчлэх төрийн үйлчилгээг сайжруулах, үйлчилгээний соёл, угтах, үдэх үйлчилгээний чанарт анхаарах. Төрийн албан хаагчдын ёс зүй, хариуцлага, харилцаа, хандлагыг дээшлүүлэх, Удирдлагын манлайллыг хэрэгжүүлэх.	Сургалтын чанарыг сайжруулах	Байгууллагаас зохион байгуулж буй сургалтыг тухайн байгууллага болон өөрийн байгууллага дээр хийж эхэлсэн. Мөн шилэн дансны цахим хуудасны мэдээ оруулалтыг байгууллага бүрээр нэг бүрчлэн хяналт шалгалт хийж тайлан мэдээг аймгийн Засаг дарга болон Иргэдийн төлөөлөгчдийн хурлын даргад сар бүр хүргүүлж байна. Үр дүн: Мэдээ мэдээллийг холбогдох албан тушаалтанд цаг тухай бүр хүргэн ажиллаж байна.	100	
ГСА-ЗД-23/01	3.6		3.6 Төрийн байгууллагуудын хамтын ажиллагаа, уялдааг сайжруулах, хамтран ажиллах.	Төрийн байгууллагуудтай хамтран ажиллах	Авилгатай тэмцэх газар, Аймгийн Прокурорын газар, аймгийн Цагдаагийн хэлтэс болон төрийн Аудитын газартай хамтран ажиллаж байна.	100	

					Үр дүн: Төрийн байгууллагын хамтын ажиллагаа сайжирна.		
ГСА-ЗД-23/01	3.7		3.7 Удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнд өөрийн биеэр оролцож, шуурхай зөвлөгөөнөөс өгсөн үүрэг даалгавар болон аймгийн Засаг даргаас хууль, тогтоомжийн хүрээнд өгсөн шуурхай үүрэг даалгаврыг хугацаанд нь биелүүлж, үр дүнг тайлагнах.	Удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнд тухай бүр оролцох	Тайлант хугацаанд удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнд өөрийн биеэр бүрэн суусан бөгөөд манай байгууллагатай холбоотой 46 үүрэг даалгавар өгснийг 18 удаагийн албан бичгээр хугацаанд нь холбогдох газарт нь хүргүүлж ажилласан. Үр дүн: Цаг үеийн мэдээллээр бүрэн хангагдана.	100	
ГСА-ЗД-23/01	3.8		3.8 Архив, албан хэрэг хөтлөлтийн стандартыг мөрдлөг болгон хэрэгжүүлэх, албан хэрэг хөтлөлтөд уламжлалт Монгол бичиг нэвтрүүлэх ажлыг эхлүүлэх.	Архив албан хэрэг хөтлөлтийн стандартыг мөрдөх	Архив, албан хэрэг хөтлөлтийн стандартыг үйл үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байгаа бөгөөд нийт 608 албан бичгийг стандартын дагуу хөтлөн солилцсон байна. -Монгол бичгийн анхан шатны мэдлэгтэй 2 албан хаагчийг албаны даргын үндэсний бичгийн анхан шатны мэдлэг олгох хувийн сургалтад хамруулж байгаа бөгөөд бусад дунд болон дундаас дээш мэдлэгтэй албан хаагчид цахим хэлбэрээр сургалтад хамрагдаж байна. -Албан хэрэг хөтлөлтийг монгол кирилл болон үндэсний бичгээр хөтлөн явуулахтай холбогдуулан төрийн байгууллагуудын холбогдох албан хаагчдын үндэсний бичгийн мэдлэгийг дээшлүүлэх, цахим бичвэр боловсруулах арга аргачлалд сургах сургалтад хамрагдан албан хэрэг хөтлөлтийн монград программыг суулган албан хэрэг хөтлөлтдөө ашиглахаар хэвлэлтийн тохиргоог хийж байгаа бөгөөд үндэсний бичгээр албан бланкийг хэвлүүлэн хүлээн авч	70	

					хосолсон хэлбэрээр хөтлөх бэлтгэл 85 хувьтай хангагдаад байна. Үр дүн: Монгол бичгийн хэрэглээ сайжирна.		
ГСА-ЗД-23/01	3.9		3.9 Байгууллагад дотоод удирдлагын ERP систем нэвтрүүлж, албан хэрэг хөтлөлтийг цахимжуулах, төрийн үйлчилгээнд тоон гарын үсэг нэвтрүүлэх, өргөдөл гомдлыг цахимаар хүлээн авч шийдвэрлэх	1. Байгууллагад дотоод удирдлагын ERP систем нэвтрүүлэх 2. Татварын тайланг илгээхэд тоон гарын үсэг нэвтрүүлэх 3. Цахимаар хүлээн авсан өргөдөл гомдыг шийдвэрсэн тоо	1. Төрийн байгууллагын дотоод удирдлагын ERP системийг байгууллагадаа бүрэн нэвтрүүлж үйл ажиллагаандаа тогтмол ашиглаж хэвшсэн. Тайлант онд 512 баримт бичгийг цахимжуулсан. Мөн байгууллагын sankhuu_audit_gs@yahoo.com и-мэйл хаягыг бүх албан хаагчид ашигладаг. 2. Албан хэрэг хөтлөлтийг ERP систем болон албаны и-мэйл хаягаар илгээж байгаа бөгөөд ERP системд байгууллагын нийт албан хаагчдыг бүртгэн эрхүүдийг нээж үйл ажиллагаандаа ашиглаж байна. Ирсэн явсан бичгийн бүртгэлийг тогтмол хөтлөн ERP системээр 10 сарын байдлаар нийт 204 албан бичгийг солилцон үйл ажиллагаандаа ашиглаж байна. Үүнд: - Ирсэн бичиг -85 - Явсан бичиг – 119 тус тус байна. Байгууллагын нийт 7 албан хаагч ERP систем болон албаны и-мэйл хаягаар үйл ажиллагаа явуулж хэвшээд байна. 3. Байгууллагын татварын тайланг илгээхдээ тоон гарын үсэг ашиглаж илгээж хэвшсэн. 4. Байгууллагын цалин хөлсийг цахим гарын үсгээр илгээж байгаа. Цахимаар өргөдөл, гомдол, санал хүсэлт ирээгүй. Харин тайлант хугацаанд иргэнээс-1 байгууллагаас 1 хүсэлт ирсэн бөгөөд гомдол шийдвэрлүүлэх тухай хүсэлтийг хуулийн дагуу буцаасан. Ээлжийн	100	

					амралтын тухай 1 өргөдлийн хариуг 2023 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн 169 дугаар албан бичгээр хуулийн хугацаанд нь шийдвэрлэж хариуг хүргүүлсэн Үр дүн: Мэдээллийг түргэн шуурхай хүргэж байна.		
ГСА-ЗД-23/01	3.10		3.10 Төрийн албан хаагчдыг сургаж, мэдлэг чадварыг дээшлүүлэх, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх. Төрийн албаны тухай хууль тогтоомжийн хүрээнд төрийн албан хаагчдыг богино хугацааны мэргэшүүлэх болон төрийн албанд анх орсон иргэдийг мэргэшүүлэх анхан шатны, төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх дунд шатны давтан сургалтанд хамруулах.	Хамрагдсан сургалтын тоо	Тайлант хугацаанд нийт ажлын байран дахь сургалт-6, мэргэшүүлэх сургалт-4, цахим сургалт-4, танхим-16 нийт 30 сургалтанд 100 хувь хамрагдсан. Мөн тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим хуудас шинэчлэгдсэнтэй холбоотой 7 удаагийн сургалт зохион байгуулсан. Тус сургалтанд давхардсан тоогоор 157 хүн хамрагдсан. Үр дүн: Мэдлэг мэргэжил дээшилж шинэ гарсан дүрэм журмыг тухай бүр нь судалж үйл ажиллагаандаа хэрэгжүүлнэ.	100	
ГСА-ЗД-23/01	3.11		3.11 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсэгт “Төсвийн байгууллага нь тухайн жилийн батлагдсан төсвийн 0.5 хувиас доошгүй зардлыг ажилтны амь нас, эрүүл мэндийг хамгаалахад зарцуулах;	Нийт зарцуулсан хөөрөнгийн хэмжээ	Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт байгууллагын албан хаагчид 100 хувь хамрагдсан. Үр дүн: эрсдлээс урьдчилан сэргийлнэ.	100	

ГСА-ЗД-23/01	3.12		3.12 Ажлын байран дахь ялгаварлан гадуурхалт аливаа хэлбэрээс урьдчилан сэргийлэх, тэдгээрийг үл тэвчих орчныг бүрдүүлэх, ажлын байрны бэлгийн дарамт, түүнээс урьдчилан сэргийлэх, хохирогчийн хүсэлт, гомдлыг ажил олгогчийн зүгээс хүлээн авч, шийдвэрлэх хэм хэмжээг хөдөлмөрийн дотоод журамдаа тусган хэрэгжилтийг ханган ажиллах	Хөдөлмөрийн дотоод журамд тусгасан эсэх	Ажил олгогч ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд ялгаварлан гадуурхах, дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, гарсан гомдлыг шийдвэрлэх талаар байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 5 дугаар зүйлд заасан. Үр дүн: Хуулийн хэрэгжилт хангагдана.	100	
ГСА-ЗД-23/01	3.13		3.13 Байгууллагын ахмадууддаа сар шинийн баяр, ахмадын баяраар хүндэтгэл үзүүлэх, тэдэнрүү чиглэсэн нийгмийн хамгааллын арга хэмжээг зохион байгуулах	Ахмаддаа хүндэтгэл үзүүлсэн эсэх	Байгууллагын ахмад Г.Цэцэгээд сар шинийн баяр болон ахмадын баяраар хүндэтгэл үзүүлж 100,0 мянган төгрөгийн нэг удаагийн мөнгөн урамшуулал, 90.0 мянган төгрөгийн гарын бэлэг олгосон. Үр дүн: Ахмаддаа хүндэтгэл үзүүлсэн.	100	
ГСА-ЗД-23/01	3.14		3.14 Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1991 оны 115 дугаар зарлиг, Засгийн газрын 2017 оны 257 дугаар тогтоол, Аймгийн Засаг даргын 2018 оны А/215 дугаар захирамжийг хэрэгжүүлэх хүрээнд Угийн бичиг хөтлөх анхан шатны сургалтанд албан хаагчдаа хамруулж	Угийн бичгийн сургалтанд хамрагдсан эсэх	Тайлант хугацаанд угийн бичиг хөтлөлтийн талаарх сургалтанд 1 удаа бүх албан хаагчид хамрагдсан. Угийн бичиг хөтлөх нь хэрхэн ашиг тустай талаар анхан шатны мэдлэг олж авч хөтөлж байгаа талаарх мэдээллээ СУГазарт хүргүүлсэн. Үр дүн: Байгууллагын албан хаагчид угийн бичгээ хөтөлж эхэлсэн.	100	

			угийн бичиг хөтлүүлсэн байна				
ГСА-ЗД-23/01			3.15 Аймгийн Засаг даргын 2019 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн А/184 дугаар захирамжийн дагуу байгууллага бүр албан хаагчдын бие бялдрыг хөгжүүлэх, чийрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах “Спортын хамтлаг”-ийг байгуулах, төлөвлөгөө, төсөв батлан хэрэгжилтийг хангаж ажиллах	албан хаагчдын бие бялдрыг хөгжүүлэх, чийрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулсаанэ эсэх	Албан хаагчдын бие бялдрыг хөгжүүлэх, чийрэгжүүлэх зорилгоор 4 албан байгууллагатай хамтран 7 хоног бүрийн 2 дахь өдрийн 19 цагаас зааланд спортоор хичээллэж чөлөөт цагийг үр бүтээлтэй өнгөрүүлж байна. Мөн биеийн тамир хариуцсан албан хаагчдын эрүүл зан үйлийг төлөвшүүлэх, эрүүл чийрэг бие бялдар, биеийн жингийн зохистой харьцаанд анхаарах, хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, Түмэн дасгалыг танилцуулах сургалтад хамрагдсан. Аймгийн Засаг даргын нэрэмжит “Спортын 4-р бага наадам”-д спортын 2 төрөлд 2 албан хаагч амжилттай оролцсон. Цэнгээнт бүжгийн сургалтад хамрагдах хугацаа болоогүй байна. Үр дүн: Ажлын байранд дасгал хөдөлгөөн хийж хэвшсэн.	100	
ГСА-ЗД-23/01			3.16 МУ-ын ерөнхий сайдаар ахлуулсан Хүүхдийн төлөө зөвлөлийн 2018 оны 03 дугаар тогтоолоор батлагдсан “Байгууллагын дэргэдэх эцэг эхийн зөвлөл”-ийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан, хэрэгжилтийг хангаж ажлыг эрчимжүүлэх	Байгууллагын дэргэдэх “эцэг эхийн зөвлөл” байгуулсан эсэх	Манай байгууллага нь байгууллагын дэргэдэх эцэг эхийн зөвлөлийг 2023 онд шинэчлэн байгуулсан. Эцэг эхийн зөвлөлөөс тайлант онд төлөвлөгөөний дагуу 2023 оны 05 дугаар сарын 31-нд “Эх үрс”-ийн баярын арга хэмжээг зохион байгуулсан. Мөн 2023 оны 08 дугаар сарын 25-ны өдөр ажилчдын хүүхдүүдэд “Боржигон өв музей”-г үзүүлсэн. Үр дүн: Эцэг эхийн зөвлөлийн үйл ажиллагаа жигдэрсэн.	100	
ГСА-ЗД-23/01	3.17		3.17 Үндэсний эх хэл, түүх соёл, Боржигин өв соёлоо дээдэлсэн аймаг болох зорилтын хүрээнд	Боржигон өв музей үзүүлсэн эсэх	Е-Mongolia үйлчилгээг олон нийтэд сурталчлах ажлын хүрээнд Цахим хөгжлийн яамнаас зохион байгуулсан сургалтад хамрагдсан. Мөн 2023 оны 08 дугаар сарын 25-ны өдөр	100	

			Боржигины түүх, өв соёлыг таниулах мэдлэг олгох зорилгоор албан хаагчид болон бусад аймгаас сургалт, туршлага солилцох уулзалтаар ирсэн хүмүүст Боржигин өв музейг үзүүлэх,		байгууллагын бүх албан хаагчид аймгийн Боржигон өв музейн үйл ажиллагаатай танилцаж музейн үзмэр үзсэн. Үр дүн: Амйгийнхаа музейн үзмэрийг үзсэн.		
ГСА-ЗД-23/01	3.18		3.18 Байгууллагын албан хаагчдыг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг шинжилгээнд бүрэн хамруулах ажлыг зохион байгуулах	урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг шинжилгээнд бүрэн хамрагдсан эсэх	Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт байгууллагын албан хаагчид 100 хувь хамрагдсан. Үр дүн: Эрсдэлээс урьдчилан сэргийлнэ.	100	
ГСА-ЗД-23/01	3.19		3.19 Ажлын байранд коронавируст халдвар (Covid-19)-аас сэргийлэх мэргэжлийн байгууллагын зөвлөмжийг мөрдөх.	Зөвлөмж мөрдөж байгаа эсэх	Ажлын байранд коронавируст халдвар (Covid-19)-аас сэргийлэх мэргэжлийн байгууллагын зөвлөмжийг мөрдөн ажиллаж байгаа. Үр дүн: Халдварас урьдчилан сэргийлнэ.	100	
ГСА-ЗД-23/01	3.20		3.20 Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах	1. Шилэн дансы тухай хуулийн хэрэгжилт 2. Шилэн дансны цахим тайлан илгээлт	Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд нийт 139 мэдээлэл байршуулсан бөгөөд хугацаа хоцроосон мэдээлэл 2 байна. - Төсөв гүйцэтгэлийн мэдээлэл – 56 - Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалтын мэдээлэл – 22 - Бусад мэдээлэл – 61 байна. Шилэн дансны цахим тайланг 3 удаа хугацаанд нь илгээсэн. Үр дүн: Шилэн дансны хуулийн хэрэгжилт 98.6% хэрэгжсэн.	98.6	
ГСА-ЗД-23/01	3.21		3.21 Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зориулалтын дагуу зарцуулах, төсвийн	Үүссэн өр, авлаганы дүн	2023 онд 232482.6 мянган төгрөгөөр батлагдсан бөгөөд 2023.09 сард төсвийн өөрчлөлт орж 243182.6 мянган төгрөг болсон. Эхний 10 сарын байдлаар 201360.0 мянган	100	

			сахилга батыг эрхэмлэн өр, авлага үүсгэхгүй ажиллах		төгрөгийн санхүүжилтийг авч 184818.1 мянган төгрөгийг зарцуулан зардлын гүйцэтгэл 91.8 хувьтай байна. Төсвийн хэмнэлтийн тухай хууль гарсантай холбоотойгоор бичиг хэрэг, шуудан холбооны зардлыг 9.8 хувиар хэмнэсэн байна. Тухайн тайлант хугацаанд өр, авлага үүсээгүй. Мөн байгууллагын үйл ажиллагаа хэвийн явагдаж байна. Үр дүн: Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт хангагдаж байна.		
ГСА-ЗД-23/01	3.22		3.22 Орон нутгийн өмчийн эзэмшүүлэх гэрээ байгуулах, өмнөх оны өмч эзэмшүүлэх гэрээг дүгнэх		Тайлант хугацаанд орон нутгийн өмчийн эзэмшүүлэх гэрээг байгуулсан бөгөөд өмнөх оны гэрээг дүгнүүлэн 94,0 үнэлэгдсэн. Үр дүн: Өмч эзэмшүүлэх гэрээг тухай бүр хийж хэвшсэн.	94	
ГСА-ЗД-23/01	3.23		3.23 Худалдан авах ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, тайлагнах		Тайлант онд 8360.0 мянган төгрөгийн хөрөнгөөр тавилга эд хогшил, тоног төхөөрөмж худалдан авахаар төлөвлөж оны эхний хагас жилдээ багтаан батлагдсан төсвийн хүрээнд 8209.5 мянган төгрөгөөр худалдан авч тайлагнасан. Үр дүн: Ажилчдын ажиллах нөхцөл сайжирсан.	100	
ГСА-ЗД-23/01	3.24		3.24 Хяналт шалгалтын дүнг аймгийн Дотоод аудитын хорооны хурлаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэх	Дотоод аудитын хурлын тоо	Тайлант онд дотоод аудитын хорооны хурлыг 2023 оны 05 дугаар сарын 09-ний өдөр хийсэн. Хурлаар 2 дотоод аудит, 2 санхүүгийн хяналт шалгалт нийт 4 хяналт шалгалтын дүнг хэлэлцүүлсэн. 2023 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр хийхээр төлөвлөөд байна. Үр дүн: Хяналт шалгалтын дүнг баталгаажуулна.	70	
ГСА-ЗД-23/01	3.25		3.25 “Тэр бум мод” үндэсний хөтөлгөөний хүрээнд тайлант хугацаанд байгууллагад	Тарьсан модны тоо	“ТЭР БУМ МОД” үндэсний хөдөлгөөний хүрээнд “Сүмбэр гарден” цэцэрлэгт хүрээлэнгийн зам дагуух 2014 оны ойн зурваст талбайд 2023 оны хавар 50ш мод нөхөн тарьж	100	

			хуваарилсан модыг тарьж ургуулах		хуваарийн дагуу нийт 16 удаа усалгаа хийсэн. Мөн Сум дундын ойн ангийн мод үржүүлгийн талбайд 44ш мод тариалж намрын цэнэг усалгааг хийсэн. Тайлант онд нийт 94 мод тарьсан. Мөн хариуцсан талбайн мод арчлалт, хамгаалалт, талбайн зэрдэг зулгаах, орчны хог хаягдлыг цэвэрлэх зэрэг ажлыг тогтмол хийж гүйцэтгэсэн. Үр дүн: Төлөвлөгөөт ажил бүрэн хийгдсэн.		
ГСА-ЗД- 23/01	3.26		3.26 Хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэх		Тайлант хугацаанд дахивар авах хоршоонд 2 удаа 8 уут цаас тушаасан. Мөн байгууллагын ойр орчмын 50м талбай болон нийтийн их цэвэрлэгээг 11 удаа хийж 35ш хогийн уут хог цэвэрлэж хаясан. Мөн ногоон худалдан авалттай холбоотой 740,0 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн. Үр дүн: Байгууллагын хог хаягдлыг ангилан ялгаж, дахиварт цаас тушааж хэвшсэн.	100	

Гэрээний биелэлт гаргасан:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ ДАРГА

/Н.АЛТАНЦЭЦЭГ/